ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр Дугаар 04 Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 798 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннаймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан суманд барьж, ашиглалтад оруулсан нийт 2,710,000,000 (хоёр тэрбум долоон зуун арван мянга) төгрөгийн өртөгтэй барилга байгууламжийг Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн эрхлэгч (М.Туул)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 02 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
04 дугаар тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын Хоёрдугаар цэцэрлэгийн
үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Биет хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цэцэрлэгийн барилга	$м^2$	$м^2$	2,653,838,000	2,653,838,000
2	Гадна гэрэлтүүлэг	ш	ш	1,040,000	15,600,000
3	Авто машин зогсоол	$м^2$	$216м^2$	18,500	3,996,000
4	Явган хүний зам	м	$480м^2$	15,000	7,200,000
5	Хашаа	1,5м	250м	55,000	13,750,000
6	Хавтан резин	30*30см	$262м^2$	28,000	7,336,000
7	Тоглоом	ш	1	4,600,000	4,600,000
8	Сандал	ш	4	200,000	800,000
9	Дүүжин	ш	2	600,000	1,200,000
10	Төмөр савлуур	ш	1	800,000	800,000
11	Хогийн сав	ш	4	220,000	880,000
12	**Нийт хөрөнгийн дүн**				**2,710,000,000 /хоёр тэрбум долоон зуун арван мянга/ төгрөг**